

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/015/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум 2025 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
	Ахлах аудитор: Т.Болор Утас: 7036-2442 Цахим хаяг: bolort@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12-21
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
4. Аудитын тайлан	22-25
4.1 Ерөнхий зүйл	22
4.2 Материаллаг байдал	22
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	22
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	23
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	24
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	25
5. Аудитын илрүүлэлт	26-31
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	32-33

Товчилсон үгийн жагсаалт

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ХХС	Хоршоог хөгжүүлэх сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ХҮДЭР СУМЫН ЗАСАГ
ДАРГА Т.ЭРДЭНЭБАТ ТАНАА

2025.03.25 № САА-2025/015/НА-СТА-ТТЗ
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Сумын ИТХ-ын тогтоолоор баталсан 2024 онд ОНХО-аар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад батлагдаагүй, өмнөх оноос шилжин хэрэгжсэн 2 төсөл, арга хэмжээнд 13,381.6 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон,
- ИТХ нь 1 албан хаагчид олгосон урамшууллаас ХХОАТ-ын 875.5 мянган төгрөг суутгаагүй,
- ИТХ нь зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, 2,546.9 мянган төгрөгийн батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан,

- ИТХ-ын нарийн бичгийн даргын ЭБАТ-ны нэмэгдлийг гүйцэтгэж буй ажлын ачаалалтай уялдуулалгүйгээр 1,860.8 мянган төгрөгийг илүү тооцож олгосон,
- ИТХ нь бодит ирцээр бус нийт төлөөлөгчдийн тоогоор тооцож, хоолны болон чадавхжуулах сургалтын зардлыг **1,792.1** мянган төгрөгөөр илүү зарцуулсан,
- ЗДТГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин түүх соёлын дурсгалт болон байгалийн цогцолбор газруудын видео бичлэг хийлгэхэд 4,879.6 мянган төгрөгийг зарцуулсан,
- ЗДТГ-ын даргын албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан нотариатын ажлыг гүйцэтгэсэн гэх үндэслэлээр ЗДТГ-ын дарга Г.Цэрэндамбад **6,652.7** мянган төгрөгийг илүү олгосон,
- ЗДТГ нь 3 албан хаагчид олгосон урамшууллаас ХХОАТ-ын 2,191.8 мянган төгрөг суутгаагүй, 1 албан хаагчид 896.0 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон, 18 албан хаагчид 10,713.5 мянган төгрөгийн урамшуулал илүү тооцож олгосон,
- ЗДТГ нь зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, 27,717.9 мянган төгрөгийн батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 22 дугаар зүйлийн 22.1.1, Нотариатын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1 дэх заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сумын ИТХ-ын “Хүдэр сумын 2024 оны тодотгосон төсөв батлах тухай” 27 дугаар тогтоолоор тайлант онд 1,848,144.8 мянган төгрөгийн татварын орлого, 814,414.4 мянган төгрөгийн татварын бус орлого нийт **3,495,364.2** мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр **2,948,023.4** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 15.7 хувиар тасалсан байна.

Аудитын гол асуудал

Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дугаар сарын 23-ны өдрийн 180 дугаар тогтоолоор аймгийн 2024 оны төсвийг тодотгож, сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 500,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 1,600,000.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Самрын нөөц тогтоогдоогүй байхад ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 3 жилийн дунджаар төлөвлөснөөс шалтгаалж, орлогын төлөвлөгөө 1,216,896.8 мянган төгрөгөөр тасарсан тул аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 588,333.1 мянган төгрөгөөр дутуу 1,011,666.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Хүдэр сумын Засаг дарга нь тайлант онд 5 зорилт, 128 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 86.7 хувийн хэрэгжилттэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,516,081.2	2,177,781.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,275,098.6	1,461,086.3
33	АВЛАГА	169,569.4	109,768.0
35	БАРАА МАТЕРИАЛ	71,413.3	606,927.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,389,536.8	5,216,099.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,389,536.8	5,216,099.5
39200	Биет хөрөнгө	5,363,833.0	5,131,423.7
39300	Биет бус хөрөнгө	25,703.8	84,675.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,905,618.0	7,393,881.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,191.1	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,191.1	-
41300	Өглөг	3,191.1	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,902,426.9	7,393,881.3
51	Засгийн газрын хувь оролцоо	6,902,426.9	7,393,881.3
51100	Засгийн газрын оруулсан капитал	287,430.8	287,430.8
51200	Хуримтлагдсан үр дүн	6,207,203.7	6,698,658.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	407,792.4	407,792.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,905,618.0	7,393,881.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,421,230.0	4,243,863.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	2,491,967.4	1,848,144.8
110	Орлогын албан татвар	498,369.7	904,988.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	520,090.6	948,923.2
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(21,720.8)	(43,935.0)
113	Хөрөнгийн албан татвар	48,516.4	83,948.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,945,081.3	859,208.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,428,400.4	1,448,918.4
120	Нийтлэг татварын бус орлого	1,428,400.4	1,448,918.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	500,862.2	946,800.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,254,600.0	3,596,863.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,092,114.1	3,437,738.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,866,178.8	2,388,612.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	604,043.1	959,351.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,059.6	127,961.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,193.7	370,351.8
2104	Хангамж, бараа материалын зардал	41,504.7	50,653.7
2105	Нормативт зардал	418.4	500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	72,084.9	81,165.3
2107	Томилолт, зочны зардал	8,584.3	9,251.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	398,353.4	121,478.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	605,936.5	667,899.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,225,935.3	1,049,125.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	162,485.9	159,124.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,166,630.1	647,000.6
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	581,870.8	155,546.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	584,759.3	491,454.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,317,667.6	-	6,317,667.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,317,667.6	-	6,317,667.6
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	584,759.3	-	584,759.3
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,902,426.9	-	6,902,426.9
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,902,426.9	-	6,902,426.9
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,902,426.9	-	6,902,426.9
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	491,454.4	-	491,454.4
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	7,393,881.3	-	7,393,881.3

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,845,127.9	3,997,889.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	2,491,967.4	1,848,144.8
110	Орлогын албан татвар	498,369.7	904,988.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	520,090.6	948,923.2
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(21,720.8)	(43,935.0)
113	Хөрөнгийн албан татвар	48,516.4	83,948.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,945,081.3	859,208.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	75,184.5	34,552.6
1181	Газрын төлбөр	364,534.9	309,497.3
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,505,361.9	515,158.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	852,298.2	1,202,944.1
120	Нийтлэг татварын бус орлого	852,298.2	1,202,944.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	500,862.2	946,800.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,682,921.3	3,030,956.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,682,921.3	3,030,956.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,456,986.0	1,981,831.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	603,232.7	959,351.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,059.6	127,961.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,004.6	373,541.0
2104	Хангамж, бараа материалын зардал	41,504.7	51,529.7
2105	Нормативт зардал	418.4	500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	78,062.9	109,690.2
2107	Томилолт, зочны зардал	8,584.3	9,251.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	398,356.6	121,713.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	194,762.2	228,292.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,225,935.3	1,049,125.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,162,206.6	966,932.7
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,621,041.6	780,945.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,621,041.6	780,945.0
2200	Дотоод эх үүсвэрээр	2,621,041.6	780,945.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(2,621,041.6)	(780,945.0)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(63,718.0)	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	63,718.0	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(1,522,553.0)	185,987.7
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,797,651.6	1,275,098.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,275,098.6	1,461,086.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,132,006.2	2,771,142.0	1,360,864.2	67.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,247,471.5	1,991,297.0	256,174.5	88.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,192,430.6	1,953,838.1	238,592.5	89.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,099,870.2	959,351.8	140,518.4	87.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,092.8	127,961.4	11,131.4	92.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	389,798.2	373,541.0	16,257.2	95.8
2104	Хангамж, бараа материалын зардал	55,722.4	50,855.4	4,867.0	91.3
2105	Нормативт зардал	679.4	500.0	179.4	73.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	98,163.7	96,790.2	1,373.5	98.6
2107	Томилолт, зочны зардал	10,523.3	9,251.0	1,272.3	87.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	148,647.4	121,713.7	26,933.7	81.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	249,933.2	213,873.6	36,059.6	85.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,040.9	37,458.9	17,582.0	68.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,040.9	37,458.9	17,582.0	68.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,818,930.7	779,845.0	1,039,085.7	42.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	65,604.0	-	65,604.0	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,132,006.2	3,191,333.4	940,672.8	77.2
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,255,875.9	3,126,824.7	129,051.2	96.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	876,130.3	64,508.7	811,621.6	7.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	240,205.1	(240,205.1)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	660,396.5	(660,396.5)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	56.0	56.0	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.0	2.0	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	27.0	27.0	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	27.0	27.0	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		29,092.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ		29,092.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		29,092.9
2104	Хангамж, бараа материалын зардал		674.2
210401	Бичиг хэрэг		455.0
210402	Тээвэр, шатахуун		219.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		14,000.0
210604	Урсгал засвар		14,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		14,418.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		14,418.6
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		29,092.9
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		29,092.9
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		13,345.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		15,747.9

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагч *Цаашид Хүдэр сумын ТТЗ гэхл* нь “*Өрхийн орлогоос-Хүдэрийн хөгжил*” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан бөгөөд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомжид дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул гэж үзлээ.

Хүдэр сумын ТТЗ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд тайлант онд бие даасан хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй бөгөөд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан холбогдох байгууллагууд хяналт хэрэгжүүлж байна.

Дотоод хяналт, шалгалтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналт, шалгалтын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүдэр сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хүдэр сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан аймгийн ТЭЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад, сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүү, бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Дээрх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүдэр сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн

захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 488,263.3 мянган төгрөгөөр буюу 7.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,275,098.6	1,461,086.3	185,987.7
Авлага	169,569.4	109,768.0	(59,801.3)
Бараа материал	71,413.3	606,927.5	535,514.1
Үндсэн хөрөнгө	5,389,536.8	5,216,099.5	(173,437.3)
Нийт хөрөнгө	6,905,618.0	7,393,881.3	488,263.3
Өр төлбөр	3,191.1	-	(3,191.1)
Засгийн газрын хувь оролцоо	6,902,426.9	7,393,881.3	491,454.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,905,618.0	7,393,881.3	488,263.3

Эх сурвалж: Хүдэр сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснуудыг тус бүрээр нь тайлбарлан доор харуулав.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,461,086.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 185,987.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	1,275,098.6	1,461,086.3	185,987.7
Төгрөг	1,275,098.6	1,461,086.3	185,987.7
Төрийн сангийн харилцах	1,275,098.6	1,461,086.3	185,987.7
Дүн	1,275,098.6	1,461,086.3	185,987.7

Эх сурвалж: Хүдэр сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлд тайлагнагдсан 686,229.2 мянган төгрөг ОНЕО-ын дансанд, 582,137.5 мянган төгрөг ОНХС-ийн дансанд, 78,259.0 мянган төгрөг ХХС-ийн дансанд, Барьцаа хөрөнгийн дансанд /тайлант онд 38,556.8 мянган төгрөгийн "Бага сургууль барих" төсөл, арга хэмжээний барьцаа нэмэгдсэн/ 114,460.6 мянган төгрөгийн үлдэгдэл тус тус байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 109,768.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 59,801.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	2,752.3	2,752.3	-
Зээлийн хүүгийн авлага	5,441.2	4,169.1	(1,272.0)
Байгууллагаас авах авлага	3,297.1	3,297.1	-
Хувь хүмүүст олгосон зээл	158,078.8	99,549.5	(58,529.3)
Дүн	169,569.4	109,768.0	(59,801.3)

Эх сурвалж: Хүдэр сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны эцсийн үлдэгдэлд дараах авлагууд тайлагнагдсан байна. Үүнд:

- Өмнөх онуудад үүссэн эзэн холбогдогч нь тодорхойгүй 2,752.3 мянган төгрөгийн ажиллагчидтай холбоотой авлага, 3,297.1 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага,
- ХХС-ийн зээлийн 99,549.5 мянган төгрөг, зээлийн хүүгийн 4,169.1 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл тайлагнагдсан байна.

Тайлант онд хугацаа хэтэрсэн /2011-2021 оны хооронд зээл авсан/ 37,411.2 мянган төгрөгийн зээлийн авлагаас 750.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 606,927.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 535,514.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бичиг хэргийн материал	23,983.6	24,243.6	260.0
Аж ахуйн материал	12,454.7	12,454.7	-
Барилгын засварын материал	-	457,552.5	457,552.5
Бусад хангамжийн материал	34,975.0	112,676.6	77,701.6
Дүн	71,413.3	606,927.5	535,514.1

Эх сурвалж: Хүдэр сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Энэ нь тайлант онд 147,257.4 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсан, аймгийн БОГ-аас 2,091.6 мянган төгрөгийн байгаль хамгаалагчийн хувцсыг үнэ төлбөргүй хүлээн авсан болон 61,537.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан, ОНХС-ийн эх үүсвэрээр санхүүжсэн, хэрэгжиж дуусаагүй 447,702.5 мянган төгрөгийн “Бага сургууль барих” төсөл, арга хэмжээг барилгын засварын материалын дансанд бүртгэсэн, ОНХО-ын болон БХНСАХ-ний эх үүсвэрээр санхүүжсэн 354,678.5 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг бусад хангамжийн материалын дансаар, ОНХС-ийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн 148,167.9 мянган төгрөгийн гудамжны гэрэлтүүлгийг аж ахуйн материалын дансаар дамжуулан хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлснээс тус тус шалтгаалсан байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 5,216,099.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 173,437.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	5,363,833.0	5,131,423.7	(232,409.3)
Барилга, байгууламж, орон сууц	2,932,731.9	2,932,731.9	-
Хуримтлагдсан элэгдэл	(369,963.6)	(470,507.1)	(100,543.5)
Авто-тээврийн хэрэгсэл	589,966.1	642,002.4	52,036.4
Хуримтлагдсан элэгдэл	(264,269.1)	(325,566.2)	(61,297.1)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	175,282.6	180,133.1	4,850.5
Хуримтлагдсан элэгдэл	(70,962.7)	(60,143.1)	10,819.7
Тавилга, аж ахуйн эд хогшил	49,295.8	44,173.7	(5,122.0)
Хуримтлагдсан элэгдэл	(24,777.6)	(22,485.2)	2,292.5
Зам, гүүрийн байгууламж	1,856,986.0	1,856,826.0	(160.0)
Хуримтлагдсан элэгдэл	(381,916.3)	(549,476.8)	(167,560.5)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	250.0	250.0	-
Бусад үндсэн хөрөнгө	1,140,388.6	1,319,956.1	179,567.5
Хуримтлагдсан элэгдэл	(296,609.8)	(443,902.5)	(147,292.7)
Дуусаагүй барилга, байгууламж	27,431.3	27,431.3	-
Биет бус хөрөнгө	25,703.8	84,675.8	58,972.1
Программ хангамж	1,379.0	1,379.0	-
Хуримтлагдсан элэгдэл	(977.2)	(1,031.2)	(53.9)
Бусад биет бус хөрөнгө	25,302.0	84,328.0	59,026.0
Дүн	5,389,536.8	5,216,099.5	(173,437.3)

Эх сурвалж: Хүдэр сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Сумын ЗДТГ, ИТХ-ын төсвийн хөрөнгөөр 47,840.8 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан,
- ЗДТГ-ын нэр дээр бүртгэлтэй боловч үнэлгээгүй байсан газрыг тайлант онд 59,026.0 мянган төгрөгөөр үнэлж, бүртгэлд тусгасан,
- БОАЖГ-аас 5,136.4 мянган төгрөгийн мотоцикл, Цагдаагийн газарт 2023 онд худалдан авсан 46,900.0 мянган төгрөгийн автомашин, ОНХС-ийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн 148,167.9 мянган төгрөгийн гудамжны гэрэлтүүлэг зэргийг комиссын актаар хүлээн авч, бүртгэл тайланд тусгасан,
- Ашиглалтын хугацаа дууссан 29,529.0 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмжийн үнийг шинэчлэн тогтоож, данс бүртгэлд тусгасан,
- Сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 16 дугаар тогтоолоор 11,363.4 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 3,037.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, 160.0 мянган төгрөгийн зам, 2,312.4 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө зэрэг нийт 17,408.3 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгасан зэргээс шалтгаалсан байна.

3.4.5 Өр төлбөр

Өр төлбөрийн данс эцсийн үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагад төлөх өглөг	3,191.1	-	(3,191.1)
Дүн	3,191.1	-	(3,191.1)

Эх сурвалж: Хүдэр сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансанд өмнөх онд тайлагнагдсан 3,191.1 мянган төгрөгийн өглөгийг барагдуулсан байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 7,393,881.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 491,454.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	287,430.8	287,430.8	-
Хуримтлагдсан үр дүн	6,207,203.7	6,698,658.1	491,454.4
Өмнөх үеийн үр дүн	5,622,444.4	6,207,203.7	584,759.3
Тайлант үеийн үр дүн	584,759.3	491,454.4	(93,304.9)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	407,792.4	407,792.4	-
Дүн	6,902,426.9	7,393,881.3	491,454.4

Эх сурвалж: Хүдэр сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт:

Сумын ИТХ-ын “Хүдэр сумын 2024 оны тодотгосон төсөв батлах тухай” 27 дугаар тогтоолоор тайлант онд 1,848,144.8 мянган төгрөгийн татварын орлого, 814,414.4 мянган төгрөгийн татварын бус орлого нийт **3,495,364.2** мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр **2,948,023.4** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 15.7 хувиар тасалсан байна.

Хүснэгт № 8. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	2,680,949.8	1,848,144.8	(832,805.0)	68.9
Цалин хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлого	532,027.5	765,907.5	233,880.0	144.0
Үйл ажиллагааны орлого	9,692.0	139,960.3	130,268.3	1,444.1
Хөрөнгийн орлого	18,461.2	36,002.3	17,541.1	195.0
Хөрөнгө борлуулсны орлого	6,769.1	7,053.2	284.1	104.2
ХХОАТ-ын буцаалт	(30,000.0)	(43,935.0)	(13,935.0)	146.4
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	5,800.0	37,403.9	31,603.9	644.9
Бууны албан татвар	1,200.0	2,895.0	1,695.0	241.3
Малд ногдуулах албан татвар	37,000.0	43,649.4	6,649.4	118.0
Улсын тэмдэгтийн хураамж	50,000.0	24,224.6	(25,775.4)	48.4
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	2,500.0	3,002.0	502.0	120.1
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	2,500.0	7,326.0	4,826.0	293.0
Газрын төлбөр	262,000.0	309,497.3	47,497.3	118.1
Дуудлага худалдаа	16,000.0		(16,000.0)	-
Ойн нөөц ашигласны төлбөр	1,724,648.4	507,751.6	(1,216,896.8)	
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	3,583.0	1,774.0	(1,809.0)	
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	33,768.6	-	(33,768.6)	-
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	5,000.0	5,632.8	632.8	112.7
Татварын бус орлого	814,414.4	1,099,878.6	285,464.2	135.1
Торгуулийн орлого	25,000.0	45,339.1	20,339.1	181.4
Бусад орлого	789,414.4	1,054,539.5	265,125.1	133.6
Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	-	-	-
Нийт орлогын дүн	3,495,364.2	2,948,023.4	(547,340.8)	84.3

Эх сурвалж: Хүдэр сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогын төлөвлөгөө тасрахад ойн нөөц ашигласны төлбөр 507,751.6 мянган төгрөг төвлөрч, 1,216,896.8 мянган төгрөгөөр тасарсан нь голлон нөлөөлсөн байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- **Цалин хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлого:** Тайлант онд Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор 765,907.5 мянган төгрөгийн орлого төвлөрч, 233,880.0 мянган төгрөгөөр давж биелсэн,
- **Үйл ажиллагааны орлого:** “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн 1072 хувьцааны 2024 оны ногдол ашгийг иргэдэд тараасантай холбоотойгоор 139,960.3 мянган төгрөгийн орлого төвлөрч, 130,268.3 мянган төгрөгөөр давж биелсэн,
- **Газрын төлбөр:** Газрын төлбөрийн ногдол нэмэгдсэн, өмнөх оны өр барагдуулснаас шалтгаалан 309,497.3 мянган төгрөгийн орлого төвлөрч, 47,497.3 мянган төгрөгөөр давж биелсэн,

- **Бусад орлого:** Самрын дуудлага худалдаа, ойн нөхөн сэргээлтийн төлбөрийн 1,054,539.5 мянган төгрөгийн орлого төвлөрч, 265,125.1 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Тасарсан орлого:

- **Ус, рашааны нөөц ашигласны төлбөр:** Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр нь аймгийн төсвийн орлого учраас тус суманд төлөвлөх шаардлагагүй, аймагт орлого нь орсон учраас орлого огт төвлөрүүлээгүй, 33,768.6 мянган төгрөгөөр тасарсан,
- **Ойн нөөц ашигласны төлбөр:** Самрын нөөц тогтоогдоогүй байхад тус орлогыг 3 жилийн дунджаар буюу өндрөөр төлөвлөсөн нь төлөвлөгөө тасрахад голлон нөлөөлсөн байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Хүдэр сумын ТТЗ-ийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 4,091,805.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 142 дугаар тогтоолоор сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 1,100,000.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 910,791.9 мянган төгрөгөөр тус тус баталсан бол дээрх тогтоолыг үндэслэн сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 140 дүгээр тогтоолоор сумын төсвийн орлогыг 2,995,364.2 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих 1,196,649.6 мянган төгрөг, малын тоо толгойн албан татвараас санхүүжих 36,000.0 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 53,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр тооцож, эх үүсвэр болон нийт зарлагыг 5,191,805.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дугаар сарын 23-ны өдрийн 180 дугаар тогтоолоор аймгийн 2024 оны төсвийг тодотгож, сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 500,000.0 мянган төгрөгөөр, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 40,200.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж баталсантай холбогдуулан сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 27 дугаар тогтоолоор дараах төсвийн тодотголыг хийсэн байна. Үүнд:

Эх үүсвэрийг **540,200.5** мянган төгрөгөөр нэмэгдүүлж:

- Ойн нөөц ашигласны төлбөрийг 500,000.0 мянган төгрөгөөр,
- ОНХС-гийн эх үүсвэрийг 40,200.5 мянган төгрөгөөр,

Зарлагыг **40,200.5** мянган төгрөгөөр нэмэгдүүлж:

- Сумын ОНХС-ийн зардлыг 40,200.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 11 хөтөлбөрийн 25 арга хэмжээг санхүүжүүлэхээр **4,132,006.2** мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,247,471.5 мянган төгрөгийг урсгал зардалд, 1,818,930.7 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 65,604.0 мянган төгрөгийг ХХС-ийн зээлд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Нийт зардлын 2,268,883.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 53,000.0 мянган төгрөгийг ХХС-ийн олгосон зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрээс, ОНХС-аас 986,992.4 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 823,130.3 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг байгууллага тус бүрээр харуулбал:

№	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
1	Сэ. Хү. Иргэдийн төлөөлөгчдийн хурал	252,485.6	227,816.3	24,669.3	90.2
2	Сэ. Хү. Засаг даргын тамгын газар	2,259,158.0	1,618,363.8	640,794.2	71.6
3	Сэ. Хү. Орон нутгийн хөгжлийн сан	1,209,866.0	595,870.4	613,995.6	49.3
4	Сэ. Хү. Сум хөгжүүлэх сан	68,604.0	2,154.6	66,449.4	3.1
5	Сэ. Хү. Сургууль	203,013.0	195,249.6	7,763.4	96.2
6	Сэ. Хү. Цэцэрлэг	64,109.3	58,062.2	6,047.1	90.6
7	Сэ. Хү. Соёлын төв	32,990.9	31,871.2	1,119.7	96.6
8	Сэ. Хү. Хүн эмнэлэг	41,779.4	41,754.1	25.3	99.9
	Нийт дүн	4,132,006.2	2,771,142.0	1,360,864.2	67.1

Эх сурвалж: Хүдэр сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 2,209,117.0 мянган төгрөг, ХХС-ийн олгосон зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрээс 64,508.7 мянган төгрөг, ОНХС-аас 917,707.7 мянган төгрөг нийт **3,191,333.4** мянган төгрөгийн санхүүжилт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **2,771,142.0** мянган төгрөг буюу **67.1** хувьтай байгаа нь урсгал зардлыг 256,174.5 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 1,039,085.7 мянган төгрөгөөр, эргэж төлөгдөх зээлийг 65,604.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ-ийн зардал нийт 151,649.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 16,257.2 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 4,867.0 мянган төгрөг, нормативт зардал 179.4 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 1,373.5 мянган төгрөг, томилолт, зочны зардал 1,272.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 26,933.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 36,059.6 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 17,582.0 мянган төгрөг зэрэг нийт 256,174.5 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх нийт 11 төсөл, арга хэмжээнд 1,818,930.7 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 8 төсөл, арга хэмжээнд 779,845.0 мянган төгрөг олгож, 1,039,085.7 мянган төгрөгийг зарцуулаагүй байна.

ХХС-аас 65,604.0 мянган төгрөгийн зээл олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр зээл олгогдоогүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус сумын ЗДТГ-ийн нэмэлт санхүүжилтийн 100131355408 дугаар дансанд аймгийн ЗДНХ-өөс 13,394.8 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогын зардалд 1,098.1 мянган төгрөг, БТСГ-аас 800.0 мянган төгрөгийн бүх нийтийн гүйлтийн арга хэмжээний зардал, үндсэн үйл ажиллагааны орлогоос 13,800.0 мянган төгрөг зэрэг нийт 29,092.9 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сумын ОНХС, ОНХО, урсгал зардлын төсвөөс 1,654,600.0 мянган төгрөгийн 17 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, баталсан байна.

Гүйцэтгэлээр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар гүйцэтгэх 2, харьцуулалтын аргаар гүйцэтгэх 2, гэрээ шууд байгуулах аргаар 4, нийт 8 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад бүрэн байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

Хүснэгт 10. Хүдэр сумын 2024 оны худалдан авах ажиллагааны тайлан:

Мянган төгрөгөөр/

Хөрөнгө оруулалтын ажлын эх үүсвэр	Нийт төсөл, арга хэмжээ		Үүнээс:					
			Гэрээ шууд байгуулах		Харьцуулалтын арга		Нээлттэй тендер шалгаруулалт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ОНХО	6	229,575.1	4	64,739.0	1	60,000.0	1	104,836.1
Сумын ОНХС	2	1,401,226.9			1	36,000.0	1	1,365,226.9
Дүн	8	1,630,802.00	4	64,739.00	2	96,000.0	2	1,470,063.0

Эх сурвалж: tender.gov.mn

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хүдэр сумын ТТЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүдэр сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/74 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын 3,254,600.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 32,546.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой **4,879.6** мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. ЗДТГ: Сумын түүх соёлын дурсгалт газар, байгалийн цогцолбор газруудыг видео бичлэг, зураг, хар дүрс, фото зурагт буулган хадгалан үлдэх зорилгоор **4,879.6** мянган төгрөгийг “Монголын баялаг өв соёл” ХХК-тай гэрээ байгуулан шилжүүлсэн боловч хүлээн авсан талаарх холбогдох нотлох баримтгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.4: “... аймаг, нийслэлийн ИТХ, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон

нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт 11. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байдал

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн тоо	Хугацаа хоцроосон
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	181	164	17
2	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	183	181	2
3	Сумын Засаг даргын Тамгын газар	183	181	2
	Нийт дүн	547	526	21

Эх сурвалж: www.shilendans.gov.mn

1. Тайлант хугацаанд Хүдэр сумын ТТЗ, харьяа байгууллагуудын мэдээлбэл зохих 27-29 төрлийн нийт 547 мэдээллээс 526 мэдээллийг хугацаанд нь, 21 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3, 6 дугаар зүйлийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Сумын ТТЗ:

1. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 1,224,648.4 мянган төгрөгөөр төлөвлөсөн атал байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд уг орлогын 85.0 хувь болох 1,040,951.1 мянган төгрөгийг бус 125,930.1 мянган төгрөгийг төлөвлөж, 915,021.0 мянган төгрөгөөр дутуу төлөвлөсөн байна.

Энэ нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1 дэх “Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно: ... ойн нөөц ашигласны төлбөрийн орлого - 85 хувь”, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.1 дэх “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь, хэмжээний доод хязгаартай тэнцэх төлбөрийн орлогын хэсгийг тухайн ашигласан нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулна.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг хууль, тогтоомжид нийцүүлэн үнэн зөв төлөвлөж, байх зөвлөмж хүргүүлэв.

2. Сумын ОНХС-аар хэрэгжих Эко энерги ресурс ХХК-аас “Бага сургууль барих” төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баталгаа **38,556.8** мянган төгрөгийг банканд бус Байгаль хамгаалах сан барьцаа хөрөнгийн 100131355501 дугаар дансанд байршуулсан байна.

Энэ нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 42 дугаар 42.1 дэх “Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана.”, 42.3 дахь “Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг дараах хэлбэрээр ирүүлж болно: 42.3.1: энэ хуулийн 42.2-т заасан дүнгээс багагүй мөнгөн төлбөрийн үүргийг захиалагчийн шаардлагаар гүйцэтгэх тухай банкны, эсхүл Монгол Улсын даатгагчийн баталгаа; 42.3.2: энэ хуулийн 42.2-т заасан дүнгээс багагүй нэрлэсэн үнэтэй Монгол Улсын Засгийн газрын үнэт цаас, Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасыг захиалагчийн шаардлагаар шилжүүлэх тухай эрх бүхий этгээдийн баталгаа.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хуульд заасны дагуу ирүүлсэн гүйцэтгэлийн баталгааг үндэслэн гэрээг байгуулж байх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны цахим хуудас хөтлөлт, худалдан авах ажиллагаа, БОХНС арга хэмжээний төлөвлөлт нь Шилэн дансны тухай, ТБОНӨХБАУХА тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 172 дугаар “Санхүүгийн нэгтгэсэн тайланд

аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 34,609.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 19,800.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	5	34,609.2	5	34,609.2	100
Зөвлөмж	1	19,800.0	1	19,800.0	100
Нийт дүн	6	54,409.2	6	54,409.2	100

/мянган төгрөгөөр/

Эх сурвалж: Хүдэр сумын ТТЗ-ийн 2022, 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХС, төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг тулган баталгаажуулсан бөгөөд харин төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “ОНХС-ийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитуудаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай.

2. Хүдэр сумын **төсвийн төвлөрүүлэн захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр** хэрэгжсэн дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

- Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 142 дугаар тогтоолоор сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 1,100,000.0 мянган төгрөгөөр баталсан бол аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 180 дугаар тогтоолоор аймгийн 2024 оны төсвийг тодотгож, сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 500,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 1,600,000.0 мянган төгрөгөөр баталсан.

Самрын нөөц тогтоогдоогүй байхад ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 3 жилийн дунджаар төлөвлөснөөс шалтгаалж, орлогын төлөвлөгөө 1,216,896.8 мянган төгрөгөөр тасарсан тул аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 588,333.1 мянган төгрөгөөр дутуу буюу **1,011,666.9** мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь “...төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **7,537,830.7** мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 7,090,128.2 мянган төгрөгийн алдааг залруулж, **447,702.5** мянган төгрөгийн залруулагдаагүй алдааг залруулах зөвлөмж өглөө. Үүнд:

Залруулсан алдаа:

1. Өмнөх оны устгалыг татаагүйгээс санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг зөрүүтэй илэрхийлсэн нийт **7,090,128.2** мянган төгрөгийн алдааг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд үйл ажиллагааны орлого, зардлыг 3,541,938.9 мянган төгрөгөөр илүү,
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд үйл ажиллагааны мөнгөн орлого, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 3,548,189.3 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн.

Залруулаагүй алдаа:

- Сумын ОНХС-ийн эх үүсвэрээр санхүүжсэн, хэрэгжиж дуусаагүй **447,702.5** мянган төгрөгийн “Бага сургууль барих” төсөл, арга хэмжээг бусад хангамжийн материал дансанд бус барилгын засварын материалын дансанд бүртгэсэн.

Өгсөн зөвлөмж: Бүртгэл тайланд ангилал зөрүүтэй бүртгэсэн хөрөнгийг 2025 оны эхний хагас жилд багтаан санхүүгийн тайланд залруулах.

Аудитаар нийт **99,891.8** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **14,676.8** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **53,952.0** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, **31,263.0** мянган төгрөгийн зөрчлийг арилгах **2** зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт:

1. Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны 4 албан хаагчид олгосон 30,672.9 мянган төгрөгийн мөнгөн урамшууллаас хувь хүний орлогын албан татвар **3,067.3** мянган төгрөгийг суутгаагүй байна.

- **Сумын ИТХ:** Нарийн бичгийн дарга Д.Цэцэгсайханд олгосон 8,755.0 мянган төгрөгөөс **875.5** мянган төгрөгийн ХХОАТ,
- **Сумын ЗДТГ:** Г.Цэрэндамбад олгосон 9,582.0 мянган төгрөгөөс 958.2 мянган төгрөг, М.Мөнхцэцэгт олгосон 7,788.9 мянган төгрөгөөс 778.9 мянган төгрөг, Ц.Бямбацэцэгт олгосон 4,547.0 мянган төгрөгөөс 454.7 мянган төгрөг зэрэг нийт 21,918.0 мянган төгрөгөөс **2,191.8** мянган төгрөгийн гэх мэт.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно: 6.3.1: цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, 22 дугаар зүйлийн 22.1 дэх “Дараах орлогыг албан

татвараас чөлөөлнө: 22.1.1: хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ХХОАТ-ыг нөхөн суутгаж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Сумын ЗДТГ:

2. 18 албан хаагчийн улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг **10,713.5** мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Нягтлан бодогч 3.Шинэхүүгийн ажлыг дүгнэж ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр тооцож олгосон боловч ЗДТГ-ын даргын 2024 оны Б/31 дүгээр тушаалаар санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хууль журам, стандартын дагуу бэлтгэж аудитын тайлангаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан гэх үндэслэлээр **896.0** мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3: Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага:

1. Зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан **30,264.8** мянган төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын ИТХ: 2,546.9 мянган төгрөгийн,

- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 450.0 мянган төгрөгийн Си Ти Эс программын төлбөр, 255.2 мянган төгрөгийн бичиг хэргийн зардал зэрэг нийт **705.2** мянган төгрөг,

- Бараа үйлчилгээний бусад зардлаас 1,434.0 мянган төгрөгийн сэтгүүл, 407.7 мянган төгрөгийн бичиг хэргийн зардал зэрэг нийт **1,841.7** мянган төгрөг.

Сумын ЗДТГ: 27,717.9 мянган төгрөгийн,

- Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардалд **7,099.7** мянган төгрөг,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас **450.0** мянган төгрөгийн Си Ти Эс программын төлбөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлаас 857.8 мянган төгрөгийн хоолны зардал, 2,288.4 мянган төгрөгийн бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс, урсгал засварын зардалд 310.0 мянган төгрөг зэрэг нийт **3,456.2** мянган төгрөг,
- Багаж, техник хэрэгслийн батлагдсан төсвөөс байгууллагын үндсэн үйл ажиллагаатай хамааралгүй арьс боловсруулах болон сүүнээс цөцгий ялгах цахилгаан тоног төхөөрөмжийн **16,712.0** мянган төгрөгийн төлбөрийг гүйцэтгэсэн байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэж заасныг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

Сумын ИТХ:

2. ИТХ-ын нарийн бичгийн даргын ЭБАТ-ны нэмэгдлийг гүйцэтгэж буй ажлын ачаалалтай уялдуулалгүйгээр 20 хувиар тооцож, Д.Цэцэгсайханд **1,860.8** мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, аймгийн ИТХ-ын 2022 оны 208 дугаар “Сумдын ИТХ-ын дарга нарт” хүргүүлсэн албан бичгээр “*ЭБАТ-ны нэмэгдлийг аймгийн Засаг даргын захирамжийг¹ жишиг болгон мэдүүлэг гаргагчдын тоонд харгалзуулан тогтоон өгч байх*” гэсэн зөвлөмжийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ЭБАТ-ны нэмэгдлийг дээрх зөвлөмжөөр тогтоосон хувь хэмжээгээр тооцон өгч байх албан шаардлага хүргүүлэв.

¹ Аймгийн Засаг даргын 2022 оны Б/14 дүгээр “Цалингийн нэмэгдлийн хувийг шинэчлэн тогтоох тухай” захирамжийн хавсралтаар баталсан “Цалингийн нэмэгдлийн хувийг тогтоосон хүснэгт”-ийн 2-т “Хүдэр сумын ЗДТГ-10%”,

3. Бодит ирцээр бус нийт төлөөлөгчдийн тоогоор тооцож, дараах **1,792.1** мянган төгрөгийг илүү зарцуулсан байна. Үүнд:

- Төлөөлөгчдийн хоолны зардлыг 522.1 мянган төгрөг,
- Төлөөлөгчдийг чадавхжуулах сургалтын зардлыг 1,270.0 мянган төгрөг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зардлыг бодит ирцээр тооцон зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

Сумын ЗДТГ:

4. Сумын ЗДТГ-ын даргын албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан нотариатын ажлыг гүйцэтгэсэн гэх үндэслэлээр ЗДТГ-ын дарга Г.Цэрэндамбад үндсэн цалингийн 40 хувиар тооцож, **6,652.7** мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, Нотариатын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь “Нотариатч ажилладаггүй сум, тосгонд ... дараах этгээд нотариатчийн үүргийг хавсран гүйцэтгэнэ: 16.2.1: сумын Засаг даргын Тамгын газрын дарга, эсхүл тус газрын хуулийн мэргэжилтэн”, сумын ЗДТГ-ын даргын албан тушаалын тодорхойлолтын 5 дугаар зорилтын 4 дэх “сумын хэмжээнд нотариатын үйлчилгээг хууль, журмын дагуу хүргэх, хууль журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан орон тоо, албан тушаалын тодорхойлолтын хүрээнд ажиллагсдын цалин хөлсийг тогтоож байх албан шаардлага хүргүүлэв.

ТТЗ:

5. Сумын ИТХ-ын тогтоолоор баталсан 2024 онд ОНХО-аар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад батлагдаагүй, өмнөх оноос шилжин хэрэгжсэн 2 төсөл, арга хэмжээнд **13,381.6** мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

- “Спорт заалны гаднах зогсоол, бохир цэвэр ус, дулааны шугам шинээр тавих” төсөл, арга хэмжээний зураг, төсөл зохиогчийн хяналтын зардал 6,381.6 мянган төгрөгийг “Хот төлөвлөлтийн хүрээлэн ХХК”-д,
- “Гадна дулааны шугамын өргөтгөлийн ажил”-ын зураг төсвийн үнэ 7,000.0 мянган төгрөгийг Зап ХХК-д.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ: 41.2.2: Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага, төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтууд болон сумын ИТХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргаж байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгээгүй, хөтөлбөр, арга хэмжээгээрх төсвийн гүйцэтгэл, нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна: 54.5.4: хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга”, 54.5.5 “нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн, үнэн зөв бэлтгэх зөвлөмж өгөв.

2. Анхан шатны баримттай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Сумын ЗДТГ нь “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-өөс эдэлгээний хугацаа, уг засвар үйлчилгээг зайлшгүй хийх шаардлагатай эсэх талаар хэлэлцсэн хурлын тэмдэглэл техникийн комиссын акт, дүгнэлтгүйгээр 31,263.0 мянган төгрөгийг албан хэрэгцээнд ашиглаж буй 3 тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэлд зарцуулсан.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Өмч хамгаалах комиссын шийдвэрийг үндэслэн автомашинд засвар үйлчилгээ хийж байх зөвлөмж хүргүүлэв.

Дээрх **зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг** Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж			
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Сумын ТТЗ	1	7,090,128.2			1	7,090,128.2								
Сумын ЗДТГ	1	447,702.5			1	447,702.5			1	447,702.5	1	447,702.5		
Дүн	2	7,537,830.7			2	7,537,830.7			1	7,090,128.2	1	447,702.5	1	447,702.5

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил				Төлбөрийн акт				Албан шаардлага				Зөвлөмж				Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал									
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Сумын ТТЗ	3	13,381.6			1	13,381.6														
Сумын ИТХ	2	7,075.3	1	875.5	1	6,199.8														
Сумын ЗДТГ	3	79,434.9	1	13,801.3	1	34,370.6	1	31,263.0												
Дүн	8	99,891.8	2	14,676.8	3	53,952.0	2	31,263.0	2	14,676.8	3	53,952.0	2	31,263.0	2	14,676.8	1	13,381.6	1	875.5

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс			
	Телбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Сумын ТТЗ	1	-	1	-		
Дүн	1	-	1	-		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Сумын ТТЗ	2	38,556.8			2	38,556.8
Дүн	2	38,556.8			2	38,556.8
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт						
Сумын ЗДТГ	1	4,879.6	1	4,879.6		
Дүн	1	4,879.6	1	4,879.6		
Нийт дүн	4	43,436.4	2	4,879.6	2	38,556.8